

## БНХАУ-ЫН ХҮН АМЫН АСУУДАЛ, ТООЛЛОГЫН ТУХАЙД

### Ч. Батцэцэг

Хүн ам зүй бол нийгэм, эдийн засаг, соёл зэрэг бүхий л салбарыг хамардаг маш өргөн хүрээтэй бөгөөд орчин үед энэ талаар шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого явуулахыг дэлхий нийтээр анхааран чухалчлах болжээ. Дэлхийн бүх хүн амын бараг 1/4 нь БНХАУ-д амьдардаг. БНХАУ байгуулагдсанаас хойш хүн амаа гурван удаа тоолоход 1953 онд 601,9 сая, 1964 онд 723,1 сая байжээ. Гурав дахь удаа 1982 онд явуулсан Хятадын хүн амын тооллого зөвхөн хятадын төдийгүй дэлхийн бүх хүн ам зүйчдийн анхаарлыг татсан үйл явдал болсон. Учир нь тухайн орны хүн амын тоо дэлхийн томоохон бүс нутаг болох Ази тивийн оршин суугчдын тоо, төлөв байдалд зонхилох нөлөөтэй, тэгээд ч НҮБ-ын хүн ам судлах үйл ажиллагаанд зориулдаг үндсэн хөрөнгөөс Хятад улсад хүн амын тооллого явуулах бэлтгэл ажилд зориулж 14 сая долларын тусламж үзүүлсэн нь үүний нуталгаа мөн. 1982 оны тооллого урьд урьдынхаас илүү өргөн хүрээтэй болж, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг төлөвлөх хийгээд хүн ам зүйн бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулахад чухал зүйл болов. Энэ удаагийн тооллогоор Хятадын 29 муж, өөртөө засах орон, эх газрын хүн ам 1008 175 288 болжээ.<sup>1</sup> Тооллогод зөвхөн хятадын нутаг дэвсгэрт амьдарч буй хүмүүс багтсан бөгөөд хилийн чанадад байдаг цагаач хятадуудыг оролцуулсангүй. Тооллогын үр дүнд эрэгтэйчүүд 519 433 369 буюу хүн амын 51,5 %, эмэгтэйчүүд 488 741 919 буюу хүн амын 48,5 %-ийг эзэлж байна<sup>2</sup> гэж хүн амын бүтцэд хүйсээр нь тодорхойлолт хийжээ. 100 эмэгтэйд 106,3 эрэгтэй ногдож байна. Хан үндэстэн нийт хүн амын 93,3% бусад 55 үндэстэн 6,7%-ийг эзэлж байна. Хүн амын 1/5 бичиг үсэггүй, дээд боловсролтой 4,4 сая хүн байна гэсэн тооцоо гарчээ. Хот суурин газар ойролцоогоор 207 сая хүн амьдарч, хотын хүн амын хувийн жин улсын нийт хүн амын 20,6% - ийг эзэлж байна. Тэд голдуу томоохон хотуудад төвлөрдөг. Жишээлбэл: Бээжинд 9,2 сая, Тяньжинд 7,8 сая, Шанхайд 11,9 сая хүн оршин суудаг.

БНХАУ байгуулагдсанаас хойш 40 жилийн дотор тухайн орны хүн ам зүйн байдалд үлэмж өөрчлөлт гарлаа. 1982 оны тооллогын дүнгээс үзэхэд, 1981 онд төрөлт 20689704 буюу 20,9% нас баралт 62 90 103 буюу 6,36%, цэвэр өсөлт 14399604 буюу 14,55 % байна.<sup>3</sup>

Хүн ам зүйн бодлого бол Хятадын Төрийн бодлогын нэг чухал хэсэг юм. Хүн ам зүйн талаар идэвхтэй бодлого явуулахтай холбогдуулан сүүлийн арван хэдэн жилд хүн ам зүй судлалын цар хүрээ үлэмж нэмэгджээ. Хүн амын асуудал болон улс ардын аж ахуйн хөгжлийн хоорондын уялдаа холбоог судлахад гол анхаарлаа хандуулж байна. Хятадын янз бүрийн бүс нутагт хүн ам зүйн талаар эрдэм шинжилгээ-судалгааны байгууллага, албуудыг бий болгож, хүн ам-зүйн боловсон хүчнийг бэлтгэх боллоо.<sup>4</sup> Тухайлбал, дээд боловсролын хүрээнд: Бээжингийн Ардын Их сургуулийн дэргэдэх хүн ам зүйн салбарын судалгааны хүрээлэн хүн ам зүйн судлал болон мөн чиглэлээр боловсон хүчин бэлтгэх гол төв болсон байна. Шанхай, Гуанжоу, Жи-

линь, Сычуань, Ланьжоу зэрэг орон нутгийн их дээд сургуулиудад судалж байна. ШУА-ийн шугамаар: 1979 онд Бээжингийн Нийгмийн шинжлэх ухааны академид анх социологийн судалгааны хүрээлэн байгуулсан нь төдөлгүй хүн амын асуудлыг судлах төв болсон юм. 80-аад оноос Тяньжин, Шанхай хот, Шаньси, Гуандун, Сычуань, Ганьсу зэрэг мужид Нийгмийн шинжлэх ухааны академийн чиглэлээр хүн ам судлалын эрдэм шинжилгээ-судалгааны 10 гаруй төв байгуулагджээ.<sup>5</sup> Хүн ам судлалын чиглэлээр мэргэжилтэн боловсон хүчнийг Хэнань, Ухань, Хэбэй, Гуаньси, Сычуань, Ляонин зэрэг мужийн Анагаах ухааны дээд сургуульд бэлтгэж байна.<sup>6</sup> Дунд сургуулийн ахлах ангийнханд зориулж «Хожуу гэрлэлт болон гэр бүл төлөвлөлт», «Хүн амын асуудал» сэдвээр хичээл зааж, багш нарыг нь Сычуаний Багшийн дээд сургуульд бэлтгэж байна.

Хятадын хүн амын судлал зөвхөн өөрийн орноор хязгаарлахгүй бусад олон орон, ялангуяа өрнөдийн эрдэмтдийн анхаарал, сонирхлыг ихээхэн татаж байна. Английн эрдэмтэн Элизабет Кролл, Делиа Дэ вин, Пенни Кэни нар «Өрх тутамд нижгээд хүүхэдтэй байх Хятадын бодлого» номоо 1985 онд хэвлүүлжээ. Түүнээс гадна Америкийн эрдэмтэн Ж. Бэннистер, С. Престон нар «Хятад дахь хүн амын үхэл ба өсөлтийн тойм», Дж. Бонгаартс, Сьюзен Гринхалф «Хятад дахь өрх тутамд нижгээд хүүхэдтэй байх бодлогыг өөрчлөх арга зам», Уайт Мартин Кинг болон Уиллям Л. Периш нар «Орчин үеийн Хятадын хотын амьдрал» зэрэг эрдэм шинжилгээ-судалгааны олон бүтээл нийтлүүлснээс харж болох юм.

Хятадын эрдэмтэд хүн амын асуудлаар олон янзын урьдчилсан тооцоо гаргажээ. Хэрвээ 1980 оноос Хятадын бүх эмэгтэй, нижгээд хүүхэдтэй байвал Хятадын хүн ам өсч 2004 он гэхэд 1054 саяд хүрнэ, хэрэв гэр бүл бүр дунджаар 1,5 хүүхэдтэй байвал хүн амын өсөлт ХХ зууны эцэс хүртэл 1125 сая, хоёр хүүхэдтэй байх тохиолдолд хүн ам 2000 он хүртэл 1217 саяар өсөөд БНХАУ байгуулагдсаны зуун жилийн ойд (2049 он) 1,5 тэрбум хүнтэй болно.<sup>7</sup> Хэрвээ нэг эмэгтэй дунджаар 2,3 хүүхэд (1978 оны төрөлтийн хэмжээ)-тэй байх тохиолдолд энэ зууны эцэс гэхэд хүн ам 1282 сая, эсвэл гурван хүүхэдтэй байвал (1975 оны төрөлтийн хэмжээ) 2000 он гэхэд 1414 сая хүртэл өснө.<sup>8</sup>

БНХАУ XXI зууны эхэн гэхэд тогтмол 1,2 тэрбум хүнтэй байхын тулд хүн амын цэвэр өсөлтийг бууруулах удаан хугацааны хөтөлбөр боловсруулан шуурхай хэрэгжүүлж эхлэв. Энэ хөтөлбөрийг биелүүлэх нь дөрвөн шинэчлэлт болон эдийн засгийн шинэтгэлийг хэрэгжүүлэх нөхцөлд зайлшгүй шаардлагатай гэж хятадын удирдагчид үзэж байна. 70-аад оны дунд үеэс хүн амын өсөлтийн эрч хурд тус орны нийгэм эдийн засгийн хөгжлийн хэтийн бодлогыг тодорхойлох гол хүчин зүйлийн нэг болсон юм. 1981 оны нэгдүгээр сард гарсан Гэрлэлтийн тухай шинэ хуульд гэрлэлтийн насыг хоёр жилээр ахиулж эмэгтэйн нас 20, эрэгтэйн нас 22 болгож,<sup>10</sup> аль болохоор хожуу гэрлэхийг уриаллаа. Уг нь эртний Хятадад гэрлэх тохиромжтой нас хойд зүгт эр нь 18—20, эм нь 15—17, өмнө зүгт 14-16 нас гэж үздэг байв. 1978 оны Үндсэн хуулийн 53-р зүйлд «улсаас гэр бүлийн төлөвлөлтийг урамшуулж дэмжлэг үзүүлнэ», «эхнэр нөхөр бологсад гэр бүлийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх үүрэгтэй гэх мэтээр олон хууль тогтоомжид гэр бүл төлөвлөлтийн тухай дүрэм тусгагджээ. 1982 онд шинэчлэн засварласан Үндсэн хуульд «хүн амын өсөлтийг эдийн засаг нийгмийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулахын тулд улсаас гэр бүлийг төлөвлөхөд оролцоно» гэснээр төлөвлөгөөт төрөлт» улсын албан ёсны бодлого боллоо. Хожуу гэрлэх, хүүхэд хожуу төрүүлэх явдал нийт хүн амын дунд эр-

чимтэй явагдаж үр хөндөх, эмнэлгийн мэс засал хийлгэх нь ихсэв. Залуу гэр бүлүүд зөвхөн ганц хүүхэд төрүүлэх үүрэг амлалт авч, «Нэг гэр бүлд нэг хүүхэд» гэдэг уриаг хэрэгжүүлж эхэллээ.

80-аад оны эхнээс зарим мужуудад ганцхан хүүхэдтэй байх үүрэг авсан өрх, гэр бүлийг хөхүүлэн урамшуулах, төрөлтийн тогтоосон хэмжээг зөрчигсдөд авах арга хэмжээний талаар удаа дараалан тодорхой журам боловсруулсан билээ. Төрөлтийг хязгаарлахаар явуулж буй бүх нийтийн ажил ялангуяа хүн амын 80 хувь нь амьдардаг Хөдөө тосгодод тодорхой бэрхшээлтэй тулгарч эхэлсэн юм. Хятадын тариачдын дунд үр удмаа эр хүнээр залгамжлуулах, өтлөх насандаа зовохгүйн тулд олон хүүхэд төрүүлэх заншил эртнээс уламжлагджээ. Тариачны өрх гэрт эр хүн онц чухал үүрэгтэй учраас нэг охинтой тариачин айл дахин хүү төрүүлэхийг хүсдэгээс үндсэн бэрхшээлүүд гарч ирлээ. 1982 онд хуралдсан ХКН-ЫН ХП их хурлаас «Хүн амын асуудал-Хэзээд хятадын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чухал асуудал байв. Гэр бүлийн төлөвлөлт нь манай улсын үндсэн бодлого мөн. Энэ зууны эцэс гэхэд манай оронд хүн амын тоо 1,2 тэрбумаас хэтрэхгүй байхын төлөө шаргуу тэмцэх нь чухал. Хүн амын хэт өсөлт нь зөвхөн хүн нэг бүрт оногдох орлогыг дээшлүүлэхэд муугаар нөлөөлөөд зогсохгүй бас үр тариа, орон сууцны хэрэгцээг хангах, боловсрол олгох, ажил хөдөлмөрөөр хангахад муугаар нөлөөлнө. Энэ нь нэн хүнд асуудал болох төдийгүй нийгмийн тэнцвэртэй байдлыг алдагдуулахад хүргэж болох юм. Үүнээс үзэхэд гэр бүлийн төлөвлөлтийн ажлыг ялангуяа хөдөө тосгонд огтхон ч сулруулж болохгүй» гэжээ. Хүн амыг төлөвлөгөөтэй өсгөх ажлыг хүчээр тулгаж болохгүй. Ард түмний ухамсар, хүсэл сонирхолд түшиглэж, сэнхрүүлэн таниулах замаар явуулахыг чухалчилж байна.

VII таван жилийн (1981—1985) төлөвлөгөөний төсөлд хүн амын тоо 1990 оны эцэс гэхэд 1113 саяас дээш өсөхгүй байх хэрэгтэй<sup>12</sup> гэж заажээ. 1990 оны хагас жилийн байдлаар нэг тэрбум 111 сая 910 мянган хүнтэй болоод байна. Тус оронд 350 сая гаруй хүүхэд, 60-аас дээш насны 91 сая хөгшид байна. Одоо Хятадад жилд 20 сая гаруй хүүхэд төрж байгаа бөгөөд хүн амын жилийн цэвэр өсөлт 15 сая гаруй, хоногт дунджаар 5 мянган хүүхэд, минутад 40 хүүхэд төрж байна.<sup>13</sup> «Нэг гэр бүлд нэг хүүхэдтэй байх» бодлогыг хэрэгжүүлэхэд хятадын хүн ам нийтдээ хөгшрөх тийшээ хандаж, нийгмийн хөгжлийн хувьд бэрхшээлтэй болно хэмээн хятадын нэрт хүн ам зүйч Лю Жэний бичсэнчлэн одоо тэтгэвэрт гарах хүний тоо 90 саяар өсчээ. 2000 онд тэтгэврийн насны хүн 120 саяар өснө гэсэн тооцоо гарчээ. Нийт хүн амын тооноос хөдөлмөрлөх чадвартай хүн 30 жилийн хугацаанд 250 саяар өссөн билээ. 2000 он хүртэл энэ насны хүмүүс 440 сая болно, харин 140 сая хүн тэтгэврийн насанд хүрнэ. Ийнхүү хөдөлмөрлөх чадвартай хүний тоо өсч ойролцоогоор 300 саяд хүрчээ. Хятадын хүн амын хөгшрөлт XX зууны эцсээс нэмэгдэж, 2020 — 2040 онд дээд цэгтээ хүрэх төлөв харагдаж байна.

БНХАУ байгуулагдахаас өмнө хүн амын үхэл маш их, ялангуяа хүүхдийн үхэл эндэл тун их байжээ. Нийт улс даяар эрүүлийг хамгаалахын салбарт шуурхай ажил зохион явуулсны үрээр зөвхөн хүүхдийн төдийгүй нийт хүн амын нас баралтын хэмжээг багасгажээ. Нас баралтын хувь 50-иад оны эхэнд 20% байснаа 1985 онд 6,57% болтлоо буурчээ.<sup>14</sup> Хүүхдийн эндэгдэл 1981 оны байдлаар 34,68% байв.<sup>15</sup> Сүүлийн үед хятадын хүн ам зүйн ухаан нярай хүүхдийн эндэгдлийг багасгах талаар онцгой анхаарч байгаа юм. Өнгөрсөн арван хэдэн жилд хүн амын эмнэлгийн зарим төрлийн үйлчилгээ сайжирч, ард түм-

ний амьдралын түвшин бүхэлдээ харьцангуй дээшилсэн нь нас баралтын хэмжээ буурахад нэлээд нөлөөлжээ.

Хот суурин газар болон хөдөө тосгодын хүн амын суурьшил нягтрал хуваарилалт нь нийгмийн үйлдвэрлэх хүчний хөгжлийн ерөнхий түвшин, нийгэм-эдийн засгийн бүтцийг харуулдаг билээ. Үйлдвэрлэл хөгжиж, амьдралын түвшин дээшлэхийн сацуу шинэ шинэ хот район бий болж, хотын суурьшил, шилжилт, хотын хүн амын тоо аажмаар нэмэгдлээ. Хотын хүн амын өсөлтийг 1980—1988 оны байдлаар харьцуулан хүснэгтээр үзүүлбэл:<sup>16</sup> (Хүний тоо саяар)

**Хүснэгт 1**

Он	Хотын хүн амын тоо	Өсөлт (жилд дунджаар)
1980	191,4	6,4
1981	201,7	10,3
1982	211,5	9,8
1983	241,3	29,8
1984	330,1	88,8
1985	382,4	40,0
1986	384	1,6
1987	441	57,0
1988	504	63,0

Том хотуудын хүн амын өсөлт, шилжин суурьших явдлыг эрс хязгаарлан, хотжил төвлөрөлийг зохицуулах арга хэмжээ нь сүүлийн үед хотын хүн ам хэт олшрохоос хамгаалахад тустай чухал зүйл болж, байна.

Хятадын хувьд нэг хүүхэдтэй байх бодлого маш чухал бөгөөд ингэснээрээ төрөлтийг багасгахад энэ арга шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байгаа юм. Ямар ч гэсэн өнгөрсөн арван жилд төрөлтийн тоо нэлээд багасчээ. 1979 онд төрөлтийн хувь 1 мянгад 33,43 ногдож байсан бол 1989 онд 1 мянгад 20,83 ногдох болжээ.<sup>17</sup>

1990 оны хоёрдугаар сард Бээжин хотноо Гэр бүлийг төлөвлөх асуудлаар бүх хятадын зөвлөлгөөн хийж, түүнд оролцогчдод хүн амын өсөлтөд хяналт тавих ажил, арга хэмжээгээ цаг алдалгүй улам чанартай явуулахгүй бол шинэчлэлт хийх, ард түмний аж байдлыг дээшлүүлэхэд ноцтой бэрхшээлтэй тулгарч болзошгүй байгааг ХКН-аас сануулжээ. Энэ зууны эцэс гэхэд БНХАУ-ын хүн ам зүйн байдал нь ажлын байрны тоог эрс олшруулж, хүнсний үйлдвэрлэл, орон сууцны барилгын ажлын хэмжээг нэмэгдүүлэхийг шаардах бөгөөд тодорхой нөхцөл байдалд хэд хэдэн сөрөг үр дагавар, тухайлбал нэг хүнд ногдох дундаж орлого багасгахад хүргэж болох юм гэж мэргэжилтнүүд үзэж байна. Дашрамд өгүүлэхэд хятадад ажилгүйдэл их, орон сууцны хангамж, тохижилт хангалтгүй, цалин хөлс бага байгаагийн сацуу гэр бүлийн хуулиа зөрчиж эрт гэрлэх, охинтай айл хүү төрүүлэхийг хүсч дахин хүүхэд төрүүлэх зэрэг элдэв бэрхшээл байгаа ажээ. Хятадын хүн амын төлөвлөлтийн бодлого нь улсынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийн хувьд чухал ач холбогдолтой боловч ард түмний эрх ашигт бүрэн дүүрэн нийцэхгүй байна. «Манай улсын хүн амын тоо маш их, төрөлт дээд цэгтээ хүрсэн өнөө үед төлөвлөгөөт төрөлтийн ажлыг ямар ч гэсэн сулруулж болохгүй. Эс тэгвэл тэмцлийн тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэх замд аюул учирна. Нярай хүүхдийн бие бялдрын бойжилт, хүүхдийн хүмүүжлийг сайжруулж, хүн амын төрөлх чанарыг дээшлүүлэхэд гол анхаарлаа хандуулах ёстой. Үү-

ний зэрэгцээ хүн амын түргэн хөгшрөх хандлагад саад хийж, зүй зохистой арга хэмжээ авах хэрэгтэй»<sup>19</sup> гэж ХКН-ын XII их хурлаас заасан билээ.

1990 оны 7 дугаар сарын 1-нээс Хятадын хүн амын дөрөв дэх удаагийн тооллого эхэллээ. Тооллогын комиссын 7 сая ажилтан 9,6 сая хав. дөр. км талбай бүхий газарт оршин суудаг 200 сая гаруй гэр бүлээр орж тооллого явуулах юм. Хүн амын тооллого 7-р сарын 10-нд дуусах бөгөөд эцсийн дүнг 1992 оны 6 дугаар сард нийтэлнэ.<sup>20</sup>

БНХАУ-д явагдаж буй хүн амын тооллого зөвхөн тухайн орны хүн амын тооллогын түүхэнд чухал үйл явдал болох төдийгүй дэлхий нийтийн ач холбогдолтой юм.

<sup>1</sup> China daily 1982. 10. 28

<sup>2</sup> КНР: политика, экономика, идеология 1982. 101 дэх тал

<sup>3</sup> Мөн тэнд, 102 дахь тал

<sup>4</sup> «Проблемы Дальнего Востока» 1983 % 3, 176 дахь тал

<sup>5</sup> Population index, vol. 47, N4 1981 p 685

<sup>6</sup> «Гуанмин жибао» 1980. Ү. 24

<sup>7</sup> «Жэньминь жибао» 1980. IV. 15

<sup>8</sup> «Жэньминь жибаря 1980. Ш. 7

<sup>9</sup> Конституции Социалистических государств». М., 1987

<sup>10</sup> Народы Восточной Азии. М., Л. 1965, С, 286

<sup>11</sup> «Жэньминь жибао» 1982. IX. 8

<sup>12</sup> «Жэньминь жибао» 1986. IV. 15

<sup>13</sup> «Үнэн» 1990. IV. 9 Синьхуа хорооны мэдээ

<sup>14</sup> Жунго тунцзи няньцзянь—1985. Бээжин, 1985 211 дэх тал

<sup>15</sup> Чайна статистикс ин бриф. 1985

<sup>16</sup> 40 лет КНР., М., «Наука», 1989, с. 220 үз.

<sup>17</sup> МОНЦАМЭ-гийн мэдээлэл: агаарын сонин агентлаг, хэвлэлийн мэдээний цоморлиг, 1990. IV. 16

<sup>18</sup> Мөн тэнд, 1990. П. 16

<sup>19</sup> Документы ХШ. Всекитайского съезда КПК. 1987, с. 31 .

<sup>20</sup> МОНЦАМЭ-гийн мэдээлэл: агаарын сонин, агентлаг, хэвлэлийн мэдээний цоморлиг. 1990. VII. 2. No 151